



Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц

Ерөнхий тайлбар No. 2 (2014)

9 дүгээр зүйл: Хүртээмж

Монгол Улс, Улаанбаатар хот

2024 он



Энэхүү гарын авлагыг Европын Холбооны хамтын санхүүжилтээр хэрэгжиж буй "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн зөрчилд хариу үзүүлэх үр нөлөөг сайжруулахад Иргэний нийгмийн байгууллагуудын хувь нэмэр" (NDICI HR/2023/451-474) төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 300 хувь хэвлэв.

Гарын авлагын агуулга нь Европын Холбооны үзэл санааг илэрхийлээгүй болно.

2024 он

Монгол хэлнээ орчуулсан Д.Тэмүүжин



Орчуулгын санаачлагч: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо

Орчуулгын санхүүжүүлэгч: Нээлттэй нийгэм форум

ISBN....

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын Конвенц (2006)

9 дүгээр зүйл

Хүртээмж

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие даан амьдрах, амьдралын бүхий л зүйлд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор Оролцогч улсууд нь хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил өөрийг нь хүрээлэн буй орчин, тээвэр, мэдээлэл харилцаа холбоо тухайлбал, мэдээлэл харилцаа холбооны технологи, систем болон нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн хэрэгслүүд, үйлчилгээг хүртэх явдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ авна. Хүртээмжтэй байх явдалд учруулж буй саад, тотгорыг илрүүлэх, устгахад чиглэсэн эдгээр арга хэмжээг *inter alia* дараах газарт авна:

а) барилга байшин, зам, тээвэр болон сургууль, орон сууц, эмнэлэг, ажлын байр зэрэг бүх төрлийн доторх болон гаднах байгууламж;

б) мэдээлэл, харилцаа холбооны болон бусад төрлийн үйлчилгээ тухайлбал, түргэн тусламжийн болон цахим үйлчилгээ.

2. Түүнчлэн Оролцогч улсууд нь дараах шаардлагатай арга хэмжээг авна:

а) Нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан объект, үйлчилгээг хүртээмжтэй байлгахад чиглэсэн наад захын стандарт, гарын авлагыг боловсруулж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

б) Нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан объект, үйлчилгээг эрхэлдэг хувийн хэвшлийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байдлыг бий болгох, бүхий л хүчин зүйлийг харгалзан үзэх явдлыг хангах;

с) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өмнө тулгарч буй хүртээмжийн асуудлаар холбогдох талуудад зориулсан сургалт зохион байгуулах;

д) нийтэд нээлттэй үйлчлэх байшин барилга, бусад байгууламжид брайл үсгээр буюу хялбар уншигдах, ойлгогдохуйц байдлаар тэмдэг, тэмдэглэгээ хийх;

е) нийтэд нээлттэй үйлчлэх байшин барилга, бусад байгууламжийн хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх үүднээс хүний туслалцаа, зуучлалын хэлбэрүүд, тухайлбал, хөтөч, уншигч, дохионы хэлний мэргэжлийн орчуулагчийг бий болгох;

ф) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүлээн авах хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжлэг, туслалцаа үзүүлэх зохих хэлбэрийг хөхиүлэн дэмжих;

г) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи, систем, үүний дотор интернэтийг хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх;

х) хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны технологи, системийн загварыг зохиох, сайжруулах, үйлдвэрлэх, түгээн борлуулахдаа эхний ээлжинд эдгээр технологи, системийг байж болох хамгийн хямд өртөгтэй байх явдлыг хангах.



**Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай
конвенц**

Түгээх.: Ерөнхий

2014 оны 5 дугаар сарын
22

Эх хувь: Англи хэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн Хороо

Арваннэгдүгээр хуралдаан

2014 оны 3 сарын 31 - 4 сарын 11

Ерөнхий тайлбар No. 2 (2014)

9 дүгээр зүйл: Хүртээмж

I. Танилцуулга

1. Хүртээмжтэй байдал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн амьдралд бие даан бүрэн дүүрэн, тэгш эрхтэй оролцох урьдчилсан нөхцөл юм. Биет орчин, нийтийн тээврээр зорчих, мэдээлэл-харилцаа холбооны технологи ба систем, түүнчлэн олон нийтэд нээлттэй, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад чөлөөтэй хандах орчин бүрдээгүй л бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд тухайн нийгмийн амьдралд тэгш оролцох боломжгүй юм. Хүртээмжтэй байдал нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай Конвенцийн үндсэн зарчмуудын нэг бөгөөд энэ нь санамсаргүй тохиолдол биш юм (3-р зүйл (f)). Түүхэн талаас нь авч үзвэл, биет орчинд болон нийтийн тээврээр зорчих нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдлөх эрх чөлөөгөө эдлэх урьдчилсан нөхцөл хэмээн яригдаж ирсэн бөгөөд энэ нь хожим Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 13-р зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Тунхаг бичгийн 12-р зүйлд тусгагдаж баталгаажсан байна. Үүнтэй нэгэн адил, мэдээлэл болон харилцаа холбооны хүртээмжийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх урьдчилсан нөхцөл хэмээн авч үзэж Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19-р зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Тунхаг бичгийн 19-р зүйлийн 2 дугаарт тусгаж баталгаажуулсан байна.

2.Түүнчлэн, иргэн бүр өөрийн харъяалагдаж байгаа орныхоо олон нийтийн үйлчилгээд тэгш байдлын үндсэн ойлголтын хүрээнд хүртээмжтэй оролцох эрхийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Конвенцын 25-р (с) зүйлд зааж баталгаажуулж өгсөн байдаг. Тус зүйлийн энэхүү нөхцөл нь хүний түгээмэл эрхийн тухай гэрээ, хэлэлцээрт хүртээмжтэй байдлын тухай тусгах гол суурь нь болж байна.

3.Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх төрлийн хэлбэрийг устгах олон улсын Конвенцид: хүн бүр тээвэр, зочид буудал, зоогийн газар, кафе, театр, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт нийтэд зориулагдсан аливаа үйлчилгээнд ижил тэгш хамрагдах эрхийг баталгаажуулсан байдаг (5 дугаар зүйлийн (f)). Ийнхүү олон улсын эрх зүйн орчинд тэгш хамрагдах эрхийг эрх зүйн үндэс суурь болгон авч үзэх жишиг өөрөө тогтсон байна. Арьс өнгө болон угсаатны хувьд ялгаатай нийгмийн бүлгийн гишүүдийг олон нийтэд нээлттэй газар, үйлчилгээнд чөлөөтэй нэвтрэхэд учирч байсан бэрхшээлийн гол шалтгаан нь тэднийг хүртээмжтэй орон зайд нэвтрэхэд саад учруулах, хүч хэрэглэхэд бэлэн байх зэргээс үүдсэн өрөөсгөл хандлагын үр дагавар байсныг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь ихэнх тохиолдолд техникийн болон хүний бүрдүүлсэн ахуй GE.14-03313 (E) буюу барилга байгууламж руу нэвтрэх шат, цахилгаан шатгүй олон давхар барилга болон мэдээлэл дутмаг зэрэг саад бэрхшээлтэй тулгарч байсан. Хүний бүрдүүлсэн ахуй нь нийгэм ба соёлын хөгжил, түүнчлэн зан заншилаас хамаардаг тул тухайн ахуй нь нийгмийн бүрэн хяналтанд байх нь ойлгомжтой. Эдгээр зохиомол бэрхшээл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг олон нийтэд зориулагдсан газар, үйлчилгээнд хамрагдах үед тохиолдох бэрхшээлээс урьдчилан сэргийлэх ухамсар, хүсэл зоригоос илүү мэдээлэл болон технологийн ноу-хау дутагдсаны үр дагавар байх нь түгээмэл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд илүү хүртээмжтэй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэхийн тулд боловсролын тасралтгүй бодлого явуулж харилцаа холбооны тусламжтайгаар мэдлэг, мэдээлэл, сурталчилгаа, соёлын кампанит ажил өрнүүлэх замаар бусдыг ад үзэх болон ялгаварлан гадуурхалтын эсрэг тэмцэж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах хандлагыг өөрчлөх явдал юм.

4.Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Конвенц болон Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх төрлийн хэлбэрийг устгах олон улсын Конвенцод хүртээмжтэй байх эрх нь олон улсын хүний эрхийн хуулийн үндсэн хэсэг болохыг тодорхойлон зааж өгсөн. Хүртээмжтэй байдлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хэрэгцээ гэдэг талаас нь авч үзэх нь чухал. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай Конвенцид хүртээмжтэй байдлыг үндсэн чухал зарчмуудын нэг хэмээн авч үзээд тус зарчим нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд иргэн, улс төр, эдийн засаг, нийгэм ба соёлын гэх мэт бусад эрхүүдээ үр дүнтэй, тэгш эдлэх амьдралын урьдчилсан чухал нөхцөл хэмээн тусгажээ. Хүртээмжтэй байдлыг тэгш эрх ба ялгаварлан гадуурхахгүй байх үүднээс авч үзэхээс гадна нийгэмд хөрөнгө оруулах, тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж ойлгох нь чухал юм.

5.Хэдийгээр мэдээлэл харилцааны технологи (МХТ)-ийг иргэд ба байгууллагууд өөр өөрөөр ойлгож тайлбарладаг боловч МХТ бол аливаа мэдээлэл, харилцаа холбооны төхөөрөмж, программ хангамжийг багтаасан буюу шүхэр хэлбэрийг агуулсан нэр томъёо гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Энэхүү тодорхойлолт нь радио, телевиз, хиймэл дагуул, гар утас, суурин шугам, компьютер, сүлжээний техник хангамж, программ хангамж зэрэг өргөн хүрээний хандалтын технологийг хамардаг. МХТ-ийн ач холбогдол нь үйлчилгээний хүрээг тэлэх, одоо байгаа үйлчилгээний тогтолцоог өөрчлөх, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэт халамжинд хамрагдаагүй, гадуурхагдсан хүн амд мэдээлэл, мэдлэг олж авах эрэлт хэрэгцээг бий болгох боломжийг нээж өгдөг. Олон улсын харилцаа холбооны Дүрмийн (2012 онд Дубай хотноо батлагдсан) 12-р зүйлд Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас (ОУЦХБ) гаргасан зөвлөмжийг харгалзан хөгжлийн бэрхшээлтэй иргэд олон улсын цахилгаан холбооны үйлчилгээнд хамрагдах эрхийг

баталгаажуулсан болно. Энэхүү зүйлийн заалтууд нь оролцогч орнуудын хууль тогтоох үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд үндэс суурь нь болж болох юм.

6.Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо нь Хөгжлийн бэрхшээлийн тухай ерөнхий зөвлөмжийн 5 дугаар зүйлдээ (1994 оны) хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боломжийг тэгшитгэх тухай НҮБ-аас тогтоосон Стандарт бүхий удирдамжийг¹ мөрдлөг болгохыг улс орнуудад уриалсан байдаг. Тус стандартад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ижил тэгш боломжийг бий болгохын тулд нийгмийн амьдралд биеэр оролцох, нийтийн тээврээр зорчих, мэдээлэл ба холбоо харилцааны хүртээмжтэй байдлын ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн байна. Энэхүү үзэл баримтлалыг 5 дугаар дүрэмд заасны дагуу боловсруулсан бөгөөд биет орчин болон харилцаа холбооны хүртээмжийг үйл ажиллагааны нэн тэргүүний чиглэл болгохыг улс орнуудад санал болгосон байна. Хүртээмжтэй байдлын ач холбогдлыг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны Ерөнхий тайлбарын 14 дүгээрт (2000) тусгагдсан эрүүл мэндийн хамгийн өндөр түвшингийн үйлчилгээ авах стандартын түвшинд авч үзэж болох юм (12-р заалт). Хүүхдийн эрхийн хороо нь Ерөнхий зөвлөмжийн 9 дүгээрт (2006 он), нийтийн тээвр болон бусад барилга байгууламж, түүний дотор төрийн байгууллагууд, зах, амралт зугаалгын газруудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нэвтрэх боломжгүй байгааг онцолсон бөгөөд энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хавчин ялгаварлан гадуурхах гол хүчин зүйл болж байгааг, түүнчлэн тэдэнд үзүүлэх эрүүл мэнд болон боловсролын үйлчилгээний хүртээмжийг эрс алдагдуулж байгааг онцлон тэмдэглэсэн байна (39-р зүйл). Хүүхдүүд амралт, чөлөөт цаг, зугаа цэнгэл, соёл, урлагийн амьдралд оролцох нь тэдэнд хүртээмжтэй байдлыг хангахад онцгой ач холбогдолтой гэдгийг Хүүхдийн эрхийн хорооноос Ерөнхий зөвлөмжийн 17 дугаар (2013 он) зүйлд дурджээ.

7.Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага болон Дэлхийн Банкнаас урд өмнө байгаагүй хамгийн том зөвлөх бүрэлдэхүүн болон хөгжлийн бэрхшээлийн сэдвээр мэргэшсэн олон зуун эрдэмтэдийн оролцоотойгоор 2011 онд Дэлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байдлын талаарх хураангуй тайланг боловсруулан гаргасан юм. Тус тайланд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орчин, тээврийн систем болон мэдээлэл, харилцаа холбооны хүртээмж нь тэр бүр хүрэлцэхгүй байгааг онцлон тэмдэглэсэн юм (хуудас 10). Тээврийн зориулалтын хэрэгсэл хүрэлцээгүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил хайх, эрүүл мэндийн үйлчилгээ авах гэх мэт үндсэн эрх нь зөрчигдөж байна. Олон оронд хүртээмжтэй байдлын тухай хуулийн хэрэгжилтийн түвшин доогуур хэвээр байгаа бөгөөд мэдээлэл, харилцаа холбооны хүртээмжгүй байдлаас болж хөгжлийн бэрхшээлтэй иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлж чадахгүй байна. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан дохионы хэлний орчуулгын үйлчилгээтэй орнуудад ч гэсэн мэргэшсэн орчуулагчдын тоо тэдний үйлчилгээний өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангаж дийлэхгүй байгаа бөгөөд орчуулагч нар нь үйлчлүүлэгчээ ганцаарчлан дагаж явах шаардлагатай байдгаас тэдний үйлчилгээг хэтэрхий өртөг өндөртэй болгож байна. Оюуны болон сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, сонсгол болон харааны бэрхшээлтэй хүмүүс уншиж болох бичгийн формат бүхий харилцааны нэмэлт болон хувилбарт хэрэгсэл дутагдаж байгаагийн улмаас мэдээлэл, харилцаа холбооны хүртээмж бэрхшээлтэй байна. Үйлчилгээний ажилтнууд зохих сургалтад хамрагдаагүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчилгээ авахад төрөл бүрийн саад бэрхшээлтэй учирч байна.

8.Телевизийг хүртээмжтэй болгох тухай Олон улсын цахилгаан холбооноос Мэдээлэл, харилцаа холбооны технологийн Глобал санаачилгатай хамтран 2011 онд гаргасан тайланд: хөгжлийн ямар нэгэн бэрхшээлтэй нэг тэрбум хүмүүсийн үлэмж хэсэг нь телевизийн аудиовизуал агуулгыг буюу үзэх ба сонсох хэлбэрээр хүртэж чадахгүй байгааг онцлон тэмдэглэсэн байна. Энэ нь тэдгээр үйлчилгээнд нэвтрэхэд шаардлагатай контент, мэдээлэл эсвэл төхөөрөмж нь дээрх үйлчилгээг хүртээмжтэй болгох боломжгүй байгаатай холбоотой юм.

9.2003 онд Женевт болсон Дэлхийн Мэдээллийн Нийгэмлэгийн дээд хэмжээний уулзалтын эхний үе шатаас эхлэн МХТ-ийн идэвхтэй бүлэг нь мэдээллийн хүртээмж хэмээх ойлголтыг хүлээн зөвшөөрсөн юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүлгээс танилцуулж, удирдан чиглүүлсэн энэхүү үзэл баримтлалыг дээд хэмжээний уулзалтаас баталсан зарчмын тунхаглалд тусгасан бөгөөд 25 -р зүйлд: "хөгжлийн талаархи дэлхий нийтийн мэдлэгийг хуваалцах, бэхжүүлэхийн гол зорилго нь эдийн засаг, нийгэм, улс төр, эрүүл мэнд, соёл, боловсролын мэдээллийн хүртээмжтэй байдлыг тэгш хангахад тулгарч буй саад бэрхшээлийг арилгах, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулах, нийтийн эзэмшлийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, олон талт бүтцийг бий болгох, туслах технологийг ашиглах зэрэг болно"² гэж заажээ.

10.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо нь оролцогч улсуудаас тавьсан илтгэлүүдийг хэлэлцэхээс эхлээд Ерөнхий зөвлөмжийн эхийг бэлтгэж боловсруулах хүртэл оролцогч талуудтай 10 удаагийн яриа хэлэлцээр хийсэн бөгөөд хүртээмжийн байдлыг бүх уулзалтын гол сэдэв болгон авч хэлэлцсэн юм. Эдгээр уулзалтаас гаргасан эцсийн дүгнэлтүүдэд хүртээмжийн байдлын тухай санал зөвлөмжүүд тусгалаа олсон. Өмнө тохиолдож байсан нийтлэг бэрхшээлүүдийн нэг нь хүртээмжтэй байдлын стандарт болон холбогдох хууль, тогтоомжийн практик хэрэгжилтэд тавих хяналтын механизм хангалтгүй байсан явдал юм. Оролцогч зарим орнуудын хувьд хяналт шалгалтыг орон нутгийн удирдлага нь өөрсдөө хариуцах бөгөөд тэдгээр нь хэрэгжилтийг үр дүнтэй хангах техникийн мэдлэг, хүн ба материалын нөөцөөр дутмаг байх нь түгээмэл. Өөр нэг нийтлэг бэрхшээл бол хамтрагч талуудад сургалт явуулаагүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний төлөөллийн байгууллагуудыг тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны хүртээмжийг хангах үйл явцад хангалтгүй оролцуулсан явдал юм.

11.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо нь хүртээмжтэй байдлын асуудлыг хууль эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрсөн. Унгар улсын иргэн Нюсти, Такач нарын жишээ (1/12010 тоот, 2013 оны 4 -р сарын 16 -ны өдөр тэмдэглэсэн үзэл бодол): Хороо нь олон нийтэд нээлттэй эсвэл үзүүлж буй бүх үйлчилгээндээ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцийн 9 дүгээр зүйлд заасны дагуу хүртээмжтэй байх ёстой гэж үзсэн. Оролцогч улсаас хараагүй хүмүүст автомат теллер машин (АТМ) ашиглах боломжийг бүрдүүлэхийг уриалсан. Хорооноос бусад оролцогч улсад хандан “санхүүгийн байгууллагуудаас үзүүлж буй банкны үйлчилгээг харааны болон бусад төрлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх наад захын стандартыг тогтоох”-ыг санал болгосон; ... өмнө нь хүрч байгаагүй банкны үйлчилгээг санхүүгийн хувийн байгууллагуудын оролцоотой аажмаар өөрчлөх, тохируулах ажлыг хүртээмжтэй болгохын тулд хяналт,

үнэлгээ хийх тодорхой, хэрэгжүүлж болохуйц, цаг хугацааны шалгуур үзүүлэлт бүхий хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх; ... шинээр худалдаж авсан бүх АТМ болон банкны бусад үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бүрэн хүртээмжтэй байлгахыг баталгаажуулах "(10.2 (а) догол мөрнөөс) тухай дурдсан.

12.Эдгээр жишиг тохиолдлууд нь хүртээмжтэй байдал бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгэмд бүрэн дүүрэн, тэгш оролцдог байх, хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө үр дүнтэй эдлэх урьдчилсан чухал нөхцөл гэдгийг харуулж байгаа бөгөөд тус Хороо нь Хүний эрхийн гэрээний байгууллагуудын үйл ажиллагааны дүрэм, тогтсон практикийг харгалзан хүртээмжийн тухай Конвенцийн 9 дүгээр зүйлийн ерөнхий зөвлөмжийг анхаарах шаардлагатай гэж үзжээ.

II. Стандарт, нормативын агуулга

13.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Конвенцийн 9 -р зүйлд "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие даан амьдрах, амьдралын бүхий л салбарт бүрэн дүүрэн оролцох боломжийг олгохын тулд оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлыг хангах талаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой бөгөөд үүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд биет орчинд болон тээврийн хэрэгслээр зорчих, мэдээлэл, харилцаа холбоо, түүний дотор мэдээлэл, харилцаа холбооны технологи, систем болон хот ба хөдөөд олон нийтэд нээлттэй буюу тэдэнд үзүүлж буй үйлчилгээ нь бусад иргэдтэй адил тэгш байх боломж нөхцлөөр хангагдсан байх ёстой " гэж заасан байдаг. Хүртээмжийн нөхцлийг бүрдүүлэхдээ гадаад орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, үйлчилгээ бүх хүрээг хамарсан цогц байдлаар шийдвэрлэх нь чухал юм. Нийтийн болон хувийн барилга байгууламж, тээврийн дэд бүтэц, тээврийн хэрэгсэл, мэдээлэл, харилцаа холбоог хариуцаж ажил , үйлчилгээ эрхэлдэг хүмүүсийн эрх зүйн чадамжийг ч гэсэн анхаарах нь чухал байна. Бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь олон нийтэд нээлттэй эсвэл тэдэнд хандсан үйлчилгээ нь төрийн өмчит байгууллагын эсвэл хувийн аж ахуйн нэгжийн өмч эсэхээс үл хамааран бүх хүмүүст хүртээмжтэй байх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэр төр нь бусад иргэдтэй адил тэгш байх ёстой бөгөөд олон нийтэд нээлттэй, үзүүлж буй бүх бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг тэгш эрхтэй хүртэх ёстой. Энэхүү хандлага нь ялгаварлан гадуурхахыг хориглосон заалтаас үүдэлтэй бөгөөд хүртээмжтэй байдалд саад учруулбаас төрийн болон хувийн хэвшлийн төлөөллөөс үл хамааран ялгаварлан гадуурхах үйлдэл гэж үзэхээс өөр аргагүй. Хөгжлийн бэрхшээлтэй бүх иргэдэд хүртээмжтэй байдал нь хөгжлийн бэрхшээлийн төрлөөс үл хамааран арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон өөр үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, өмч хөрөнгө, төрсөн газар болон ялгаатай бусад нөхцөл, хууль эрх зүй ба нийгмийн байдал, хүйс, нас харгалзахгүйгээр боломжтой байх ёстой. Хүртээмжтэй байдал нь ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нас, хүйсийг тусгайлан авч үзэх ёстой.

14.Конвенцын 9 -р зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэд бие даан амьдрах, нийгэмд бүрэн дүүрэн, бусадтай адил тэгш эрхтэй оролцох, хүний эрх, үндсэн эрх чөлөөг хязгааргүй эдлэх урьдчилсан нөхцөл болох хүртээмжийн талаар тодорхой заасан байдаг. Түүнчлэн 9 дүгээр зүйл нь төрийн үйлчилгээнд тэгш хамрагдах эрхийн тухай Иргэний эрх болон улс төрийн эрхийн тухай олон улсын Тунхаг бичиг 25 (в) болон Арьс өнгөөр ялгаварлан

гадуурхах бүх төрлийн хэлбэрийг устгах тухай Олон улсын конвенцийн 5 дугаар зүйлд заасанчлан хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийтийн хэрэгцээнд зориулагдсан аливаа газар, үйлчилгээнд хандах эрхтэй (f) зэрэг хүний эрхийн тухай одоогийн гэрээнүүдээс үүдэлтэй санааг оруулсан. Хүний эрхийн гол цөм болсон эдгээр үндсэн хоёр гэрээг батлах үед дэлхийг эрс өөрчилсөн интернэт гэж байсангүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц нь МХТ -ийн хүртээмжийг хөндсөн 21 -р зууны хүний эрхийн тухай анхны гэрээ бөгөөд үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд шинээр өөр эрхийн нөхцөл үүсгээгүй болно. Түүнчлэн, тэгш эрхийн тухай олон улсын эрх зүйн хүрэн дэх ойлголт нь сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд өөрчлөгдөж, үзэл баримтлалын хувьд албан ёсны тэгш байдлаас бодит байдал руу шилжсэн нь оролцогч улсуудын хүлээх үүрэг хариуцлагад нөлөөлж байна. Үүнд хүртээмжийг хангахад улс орнуудын хувьд шинээр хүлээх үүрэг хариуцлага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх явдал болж байна. Иймд хүртээмжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн хүрээнд авч үзэх хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байх эрхийг хүртээмжтэй байдлын стандартыг чанд мөрдсөнөөр хангаж өгнө. Олон нийтэд зориулагдсан эсвэл тэдэнд нээлттэй объект, байгууламж, бараа, үйлчилгээнд нэвтрэх саад бэрхшээлийг бүрэн арилгаж хүртээмжтэй болгохын тулд системтэй, хамгийн гол нь хяналтын тасралтгүй үйл ажиллагаа чухал юм.

15.Шинээр үүсэн бий болж байгаа аливаа бараа, бүтээгдэхүүн, барилга байгууламж, технологи, үйлчилгээ нь бүх нийтээр дагаж мөрдөх түгээмэл загварт нийцсэн байх ёстой бөгөөд тэдгээр нь ердийн хэрэглэгчид болон түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэр төр, олон талт онцлог байдлыг бүрэн харгалзсан, ижил тэгш эрхтэй, элдэв саад бэрхшээлгүй нэвтрэх боломжийг хангасан байх ёстой. Энэ нь тухайн хувь хүн нэг орон зайгаас нөгөөд шилжих хөдөлгөөний хязгааргүй гинжин хэлхээг бий болгох бөгөөд үүнд тухайн байгууламжийн дотор байгаа аливаа орон зайд хүн нэвтрэх, хөдлөхөд ямар ч саадгүй байх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон бусад хэрэглэгчид гудамж талбайд чөлөөтэй зорчих, барилгын доод давхрын тээврийн хэрэгсэлд чөлөөтэй нэвтрэх зэргээр ямарч саадгүй хөдөлж, мэдээлэл, харилцаа холбооны хэрэгслийг ашиглах, нийтийн зориулалттай барилга байгууламж руу чөлөөтэй нэвтэрч явах, шаардлагатай гэж үзвэл техникийн болон бусдын тусламж дэмжлэгийг авах боломжоор хангагдсан байх ёстой. Нийтийн зориулалттай байгууламжийн загвар хийц нь техник хэрэгслийг ашиглах хэрэгцээ шаардлагыг тэр бүр бүрэн төгс хангах боломжгүй. Барилга байгууламжийн зураг төслийг хийхдээ барилгыг аль болох өртөг багатай байхаар бодож боловсруулдаг, гэхдээ барилга байгууламжийг эхнээс нь хүртээмжтэй байдлаар төлөвлөхөд ихэнх тохиолдолд барилгын нийт өртөгийг нэмэгдүүлэхгүй байх боломж бий, зарим тохиолдолд бага хэмжээгээр нэмэгдэж ч магад юм. Нөгөөтэйгүүр, барилга байгууламжийг хүртээмжтэй болгохын тулд зарим тохиолдолд, ялангуяа түүхэн барилга байгууламжийн хувьд зардал нь харьцангуй их байж болох юм. Барилга байгууламжийн зураг төсөл нь анхандаа хэмнэлттэй харагдаж байж болох боловч хүртээмжтэй холбоотой элдэв саад бэрхшээлийг арилгах зориулалт бүхий зардлууд нь барилга баригдсаны дараа байнга гарч ирэх саад бэрхшээлүүдийг нэг мөр шийдсэн гэсэн үг биш юм. Мэдээлэл, харилцаа холбоо, түүний дотор МХТ -ийн хүртээмжийг бүр анхнаас нь зэрэг шийдэж явах ёстой бөгөөд учир нь барилга байгууламж баригдаж дууссаны дараа интернет, МХТ –ийн асуудлыг шийдэх нь зардлыг нэмэгдүүлж болзошгүй. Тиймээс зураг төсөл болон бүтээгдэхүүнийг

боловсруулахдаа МХТ -ийн хүртээмжийг анхнаас нь хамт авч үзэх нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй байдаг.

16.Түгээмэл загварын хэрэглээ нь нийгмийг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс гадна бүх хүмүүст хүртээмжтэй болгодог. 9-р зүйл нь хүртээмжтэй байдлыг хот, хөдөөд ижил тэгш хангах үүргийг оролцогч улсуудад шууд ногдуулсан нь ач холбогдолтой юм. Хүртээмжтэй байдал нь алслагдсан, хөгжлийн хувьд буурай хөдөө орон нутагтай харьцуулахад том хотуудад ихэвчлэн илүү сайн байгааг нотлох баримт харуулж байна. Гэвч хотжих үйл явц хурдацтай хөгжиж байгаа орчинд ялангуяа барилга байгууламж, тээвэр, үйлчилгээний газар хөгжлийн бэрхшээлтэй иргэд нэвтрэхэд нэмэлт саад бэрхшээлүүдийг бий болгож байна, тухайлбал: хүн ам хэт нягтаршсан, хөл хөдөлгөөн ихтэй хот суурин газарт мэдээлэл, харилцаа холбооны илүү нарийн төвөгтэй үйлдэл бүхий үйлчилгээнүүд бий болсоор байна. Хот ба хөдөөгийн аль алинд нь байгалийн болон түүх, соёлын өв бүхий хэсгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэд чөлөөтэй нэвтэрч сэтгэл хангалуун байх боломжтой орчин нөхцөл байх ёстой.

17.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт оролцогч улсууд хүртээмжтэй байдалд тулгарч байгаа саад бэрхшээлийг илрүүлэн дараахи тохиолдолд тэдгээрийг арилгахыг шаарддаг. Үүнд:

(а) Барилга, зам, тээвэр болон бусад дотор болон гадна байгууламж, үүнд сургууль, орон сууц, эмнэлгийн байгууллага ба ажлын байр;

(б) Мэдээлэл, харилцаа холбоо, бусад үйлчилгээ, үүнд цахим үйлчилгээ, яаралтай тусламжийн үйлчилгээ орно.

Дээр дурдсан дотор болон гадна байгууламж гэсэн ойлголтод хууль сахиулах байгууллага, шүүх, шорон, нийгмийн байгууллагууд, нийгмийн харилцан үйлчлэл, амралт зугаалгын газар, соёл, шашин, улс төр, спортын үйл ажиллагаа, худалдаа эрхэлсэн байгууллагууд багтаж байна. Бусад үйлчилгээ гэдэгт шуудан, банк, харилцаа холбоо, мэдээллийн үйлчилгээ багтаж байгаа юм.

18.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт олон нийтэд нээлттэй үйлчилгээ үзүүлж буй байгууламж, үйлчилгээнд хүртээмжийг хангахын тухай үндэсний хэмжээний наад захын стандартыг боловсруулж, нийтлэх, сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах тухай оролцогч улсуудын авах ёстой арга хэмжээг тусгасан болно. Эдгээр стандартууд нь бусад оролцогч улсуудын стандартад нийцсэн байх ёстой бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд иргэний харьяаллаас үл хамааран харилцан чөлөөтэй зорчих (18 -р зүйл) үйлчлэлийг зохицуулах зорилготой юм. Оролцогч улсууд нь олон нийтэд нээлттэй буюу үйлчилгээ үзүүлж буй болон үйлчилгээг санал болгож буй өөрийн орны бүх хувийн байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй байдлыг бүх талаас нь харгалзсан байх шаардлагыг тавих үүрэгтэй (art. 9, para. 2 (b)).

19.Хүртээмжтэй байдлын хомсдол нь ихэвчлэн аюулгүй байдлын болон техникийн ноу-хаугийн талаар мэдлэг хангалтгүй байдгаас шалтгаалдаг бөгөөд 9-р зүйлд оролцогч улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байх талаар сонирхогч бүх талуудад тусгай сургалт явуулахыг шаардсан байна (2 (в)-ийн хэсэг). Түүнчлэн 9-р зүйлд, сонирхогч талууд гэдэгт тооны хувьд бус тэдгээрийн жагсаалтад зайлшгүй байх шаардлагатай: барилгын зөвшөөрөл олгодог эрх бүхий байгууллага, өргөн нэвтрүүлгийн зөвлөл, МХТ-ийн тусгай зөвшөөрөл олгодог байгууллага, инженер, дизайнер, архитектор, хот төлөвлөлт, тээврийн байгууллага, үйлчилгээний ажилтнууд, эрдэм шинжилгээний нийгэмлэгийн гишүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдгээрийн эрх ашгийг хамгаалдаг байгууллагууд багтсан байх ёстойг дурдсан байна. Сургалтад зөвхөн бараа, үйлчилгээг зохион бүтээж санал болгогчдыг бус, бас тэдгээрийг гардан үйлдвэрлэж бүтээдэг хүмүүсийг хамруулах ёстой. Нэмж хэлэхэд, бүтээгдэхүүн боловсруулж үйлдвэрлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шууд оролцоог хөхүүлэн дэмжих нь хүртээмжтэй байдлын өнөөгийн хэрэгцээг ойлгох, хүртээмжтэй байдлын үр нөлөөг тодруулж сайжруулахад тус дэм болох юм. Эцсийн эцэст тухайн барилга хүртээмжтэй байх ажлыг барилгын талбай дээр ажиллаж байгаа барилгачид л гүйцэтгэж байгаа. Тиймээс хүртээмжтэй байдлын стандартыг бодитоор хэрэгжүүлэхийн тулд эдгээр бүх бүлгүүдийг сургалтад хамруулж хяналтын системийг бий болгох нь чухал.

20.Нийтэд зориулсан болон өргөн олонд нээлттэй бусад газруудад хөдөлгөөний чиг баримжааг зохицуулах зориулалтын тэмдэг тэмдэглэгээ, хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбоо, туслах үйлчилгээ байхгүй бол хөгжлийн бэрхшээлтэй зарим иргэдэд хүндрэл учирч болзошгүй юм. Тиймээс, 9 дүгээр зүйлийн 2 (d) ба (д) хэсэгт олон нийтэд нээлттэй барилга байгууламж болон бусад газруудад хүртээмжийг хөнгөвчлөхийн тулд Брайл, унших ба ойлгоход хялбар, мэдээллийн дүрс тэмдэглэгээ байх ёстой бөгөөд өөрийн биеэр шууд тусламж үзүүлэх зуучлагч, тэр дундаа хөтөч, зар уншигч болон дохионы хэлний мэргэжлийн орчуулагч, хэлмэрчээр хангах ёстой хэмээн заасан байна. Барилга, байгууламж дотор хөдөлгөөний чиг баримжааг сануулах ийм тэмдэг, тэмдэглэгээ хийгээгүй, мэдээлэл, харилцаа холбоо болон дэмжлэг үзүүлэх бусад үйлчилгээ байхгүй бол хөгжлийн бэрхшээлтэй олон иргэд ялангуяа танин мэдэхүйн бэрхшээлтэй хүмүүст хөдөлгөөн, үйлдэл хийхэд саад учирч магадгүй юм.

21. Мэдээлэл, харилцаа холбооны хүртээмж үгүй бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзэл бодол, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх эрх чөлөө болон бусад үндсэн эрхүүд, чөлөөтэй байх эрх нь ноцтойгоор зөрчигдөж бас хязгаарлагдаж болзошгүй. Тиймээс Конвенцийн 9 дүгээр зүйлийн 2 (f)-ээс (g) хэсэгт оролцогч улсууд хөтөч, зар уншигч, дохионы хэлний мэргэжлийн хэлмэрч зэрэг шууд тусламж үзүүлэгч, зуучлагчдыг дэмжих (2 (д)) болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэх бусад тохиромжтой хэлбэрийг өргөжүүлэх ба хөгжүүлэх ёстой гэж заасан байдаг. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл олж авах боломжоор хангахын зэрэгцээ тэдэнд зайлшгүй хүртээмжтэй байх стандартыг хэрэгжүүлэх замаар мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи, систем, тэр дундаа интернетэд нэвтрэх боломжийг дэмжихэд чиглэсэн тусламж, дэмжлэг үзүүлэх нь чухал. Мэдээлэл, харилцаа холбооны технологи нь форматын (хэмжээ ба

хэлбэрийн) хувьд унших болон ойлгоход хялбар, нэмэлт болон хувилбарт загвар ба аргууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тус дэмтэй, ашиглаж хэрэглэхэд хялбар байх ёстой.

22. Шинээр нэвтрүүлэх технологиуд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгэмд бүрэн ба тэгш оролцоог хангахад дэмжлэг үзүүлэх нь ойлгомжтой боловч тэдгээрийн гол зорилго нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжийг нь хангахуйц байдлаар бүхнийг боловсруулж үйлдвэрлэсэн байх ёстой юм. Шинээр хөрөнгө оруулах, судалгаа шинжилгээ хийх, үйлдвэрлэл эрхлэх нь шинээр саад хотгор учруулах бус харин ч тэгш бус байдлыг аль болох арилгахад хувь нэмэр оруулах ёстой. Тийм учраас 9 дүгээр зүйлийн 2 (h) хэсэгт хүртээмжтэй байдлыг хангахын тулд мэдээлэл, харилцаа холбооны технологи, системийг зохион бүтээх, хөгжүүлэх, үйлдвэрлэх, түгээх ажлыг бүр анхан шатнаас нь өртгийн хувьд аль болох бага зардлаар, мөн хүртээмжтэй байхаар зохион байгуулахыг оролцогч улс орнуудад уриалсан байна. Сонсголыг дэмжигч систем, тухайлбал сонсголыг дэмжих замаар орчноо мэдрэх төхөөрөмж болон сонсголын зүүгч аппарат , мөн барилга байгууламжаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг яаралтай нүүлгэн шилжүүлэх үед ашиглах тусгай зориулалт бүхий тоноглогдсон зорчигчийн лифт зэрэг нь хүртээмжтэй байдлыг хангах үйлчилгээнд гарч байгаа технологийн дэвшлийн энгийн жишээнүүд юм.

23. Хүртээмжтэй байх нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даан амьдрах, нийгэмд бүрэн, тэгш оролцох урьдчилсан нөхцөл мөн гэж Конвенцийн 19 дүгээр зүйлд нэгэнт заасан тул биет орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи, түүнчлэн олон нийтэд нээлттэй барилга байгууламж ба үйлчилгээнд хүртээмжтэй байдлыг үгүйсгэх юм бол ялгаварлан гадуурхалтын түвшинд адилтган авч үзнэ. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх хүчин төгөлдөр хууль тогтоомж, дүрэм зохицуулалт, хэрэгжиж буй ёс журам болон практикийг өөрчлөх ба хүчингүй болгох нь тэднийг ялгаварлан гадуурхах явдал мөн” (4-р зүйлийн 1 дэх хэсгийн b) хэмээн заасан нь оролцогч бүх улсын хүлээх үндсэн нийтлэг үүрэг юм. “Хөгжлийн бэрхшээлийг оролцогч улсууд агуулгын энэхүү түвшинд ойлгож ялгаварлан гадуурхалтын аливаа илэрлийг хориглож, ялгаварлан гадуурхалтын эсрэг эрх зүйн тэгш бөгөөд үр дүнтэй хамгаалалтыг бүх талаар баталгаажуулна” (5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг) гэж заасан. “Тэгш байдлыг бүх талаар дэмжих болон ялгаварлан гадуурхалтыг устгахын тулд оролцогч улсууд өөрийн нөхцөлд тохируулан боломжит бүх арга хэмжээг шат дараалалттай авч хэрэгжүүлнэ” (5-р зүйлийн 3 дахь хэсэг).

24. Шинээр төлөвлөгдсөн, баригдсан эсвэл байгуулсан бүх объект, дэд бүтэц, бараа, бүтээгдэхүүнд хүртээмжийг хангахын тулд хүлээх үүрэг хариуцлага болон одоо байгаа биет орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, түүнчлэн олон нийтэд нээлттэй үйлчилгээнд хүртээмжийг хангахад тохиолдож байгаа саад бэрхшээлийг арилгах үүрэг хариуцлагын хооронд дахь зааг ялгааг маш тодорхой зааж өгөх хэрэгтэй. Оролцогч улсуудын хүлээх өөр нэг нийтлэг үүрэг бол “олон нийтэд зориулж үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээ, багаж хэрэгсэл болон тоног төхөөрөмжид судалгаа шинжилгээ хийж, Конвенцийн 2-р зүйлд зааснаар, тэдгээрийг хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, хэрэгцээ, хэрэглээг харгалзан дасан зохицоход нь хялбар, бас хямд байхаар, түүнчлэн хүрэлцээг нь хүртээмжтэй, мөн стандарт ба удирдамжийн хүрээнд тэдгээрийг нийт иргэд

бас ашиглаж болохоор хувилбартай байхаар хөгжүүлэх явдал чухал юм” (4-р зүйлийн 1 (f) хэсэг) хэмээн заасан байдаг. Бүх шинэ объект, дэд бүтэц, тоног төхөөрөмж, бараа, бүтээгдэхүүн болон үйлчилгээ нь түгээмэл загварт тавигдах зарчим, шаардлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд бас бүрэн ашиглах боломжтой байхаар хийгдэх ёстой. Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эдүгээ байгаа аль ч орчин, орон зай, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо болон бусад олон нийтэд нээлттэй үйлчилгээг ашиглах боломжоор хангах үүрэгтэй. Эдгээр үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхэд мэдээж үе шаттай арга хэмжээ хэрэгтэй учраас оролцогч улсууд одоо байгаа саад бэрхшээлийг арилгахын тулд цаг хугацаагаа тодорхой төлөвлөж хангалттай нөөц хүчийг оновчтой хуваарилах ёстой болно. Цаашилбал, хүртээмжийг хангахын тулд оролцогч улсууд эрх бүхий өөр өөр байгууллагууд (бүс нутгийн болон орон нутгийн эрх баригчдыг оролцуулан) болон бусад байгууллагуудын (хувийн аж ахуйн нэгжийг оролцуулан) гүйцэтгэх үүргийг тодорхой зааж өгөх ёстой. Оролцогч улсууд хүртээмжтэй байдлыг хангахын тулд үр дүнтэй хяналтын механизмыг бий болгох хэрэгтэй бөгөөд хүртээмжтэй байдлын стандартыг хэрэгжүүлээгүй этгээдийн үйлдлийг илрүүлж түүний эсрэг хориг арга хэмжээ авах үүрэгтэй.

25. Хүртээмжтэй байдал нь нийгмийн бүлэг хэсгүүдтэй холбоотой байдаг боловч орчныг хүртээмжтэй болгон тохижуулах нь тусгай хэрэгцээтэй иргэдэд хамаатай. Энэ нь хүртээмжтэй байдлыг хангах үүрэг нь бүр анхнаасаа л байх ёстой үүрэг гэсэн үг юм. Тийм учраас оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй иргэд тухайн газар нэвтрэх, орон зайг ашиглах, үйлчилгээ авахад гарч байгаа саад бэрхшээлийн талаар санал, гомдол, хүсэлт гаргахаас нь өмнө хүртээмжтэй байдлыг хангасан байх үүрэгтэй. Оролцогч улсууд хүртээмжтэй байдлын талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр стандарт боловсруулж батлах ёстой бөгөөд тэрхүү стандартыг үйлчилгээ үзүүлэгч, барилгын компаниуд болон бусад хамтрагч талууд үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах шаардлагатай. Хүртээмжтэй байдлыг хангах стандарт нь өргөн хүрээг хамарсан бөгөөд зайлшгүй стандарчлагдсан байх ёстой. Хүртээмжийн стандарт нь ховор согогтой иргэдийн хувьд, стандартад тэр бүр тооцож оруулах боломжгүй, эсвэл хүртээмжтэй байдлын санал болгож буй горим, арга, хэрэгслийг ашиглах боломжгүй ч юм уу(жишээлбэл: Брайл үсгийг унших боломжгүй ч юм уу) , эсвэл иргэдийн бусад онцлогийг тусгаагүй байж болно. Ийм тохиолдолд орчныг тэдний онцлогт тохируулан тусгайлан тохижуулж болно. Конвенцид оролцогч орнуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байх нөхцлийг аажмаар сайжруулах үйл явцад эдийн засгийн хэмнэлт гаргаж болохгүйг заасан байдаг. Хүртээмжтэй байдлыг хэрэгжүүлэх үүрэг нь зайлшгүй хүлээх ёстой үүрэг, өөрөөр хэлбэл, хүртээмжтэй байдлыг хангах үүрэгтэй байгууллага нь хөгжлийн бэрхшээлээс үүдсэн элдэв бэрхшээлээр шалтгаалан хүртээмжтэй байдлыг орхигдуулсан гэдгээ зөвтгөх боломжгүй. Нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг харгалзаж орчныг тохижуулах нь тухайн аж ахуйн нэгжид хэт их дарамт нэрмээс болохгүй бол тус үүргийг хэрэгжүүлэхэд мэдээж хялбар байж болно

26. Ажлын байр ба сургууль зэрэг ямарч орчин нөхцөлд тусгай хэрэгцээтэй иргэдэд таатай орчин нөхцөл бүрдүүлэх үүрэг нь тэдэнд бусадтай адил тэгш эрх эдлэх боломжийг анхнаас нь бий болгосон байх ёстой гэсэн санаа юм. Өөрөөр хэлбэл, хүртээмжтэй байх

стандарт нь зүгээр л нэг шалгуур үзүүлэлт гэхээсээ илүү амьдрал дээр өдөр тутам хангагдаж байх ёстой хэрэгцээ юм. Тухайн орчин нөхцлийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох зорилгоор бүрдүүлж болно. Таатай орчин нөхцөл бүрдүүлэхийн гол зорилго нь хувь хүний нэр төр, бие даасан байдал, сонголтыг харгалзан ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш байдлыг хангах үүднээс хувь хүний эрхийг хамгаалах зорилготой юм. Энэ утгаараа хөгжлийн ховор тохиолдох согогтой хүний хувьд хүртээмжийн стандартын хүрээнээс ангид, өөр орчин нөхцлийг ч бүрдүүлэх шаардлага гарч болно.

III. Оролцогч талуудын хүлээх үүрэг

27. Хэдийгээр биет орчин, тээвэр, мэдээлэл ба харилцаа холбоо болон олон нийтэд нээлттэй үйлчилгээний хүртээмжийг хангах нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд иргэний болон улс төрийн эрхээ бүрэн дүүрэн эдлэх урьдчилсан нөхцөл болдог боловч оролцогч улсууд энэхүү хүртээмжийг аажмаар хангах бөгөөд үүнд шаардлагатай гэж үзвэл олон улсын хамтын ажиллагааны хэлбэрийг ч ашиглаж болно.

28. Тулгарч байгаа саад бэрхшээлийг тодорхойлон тэдгээрийг арилгахын тулд нөхцөл байдлын дүн шинжилгээг үр дүнтэй арга замаар, богино ба дунд хугацаагаар тооцож хийж болно. Хамгийн гол нь тэдгээр саад бэрхшээлийг тасралтгүй, системтэй арга замаар, аажмаар, тууштай л арилгах хэрэгтэй. Оролцогч орнууд өөрийн үндэсний хэмжээний хүртээмжийн стандартыг баталж, сурталчилж, хяналт тавьж ажиллах үүрэгтэй. Хэрэв холбогдох ийм хууль, тогтоомж баталж амжаагүй бол эрх зүйн орчныг бүрдүүлэх нь эхний алхам болно. Оролцогч улсууд хууль болон түүний хэрэгжилтэд элдэв алдаа, цоорхой гаргахгүйн тулд хүртээмжийн талаарх холбогдолтой бүх хууль тогтоомжийг нарийвчлан судалсан байх шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй байдлын тухай хуулиудад, ялангуяа хүртээмжтэй байдлын тодорхойлолтын тухайд МХТ-ийг тусгаагүй байх нь түгээмэл тохиолддог. Тухайлбал: худалдан авалт, хөдөлмөр эрхлэлт, боловсрол зэрэг салбаруудад хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахгүй байх, тэдэнд хүртээмжтэй байх тухай баталсан хуулиудад орчин үеийн олон төрлийн бараа, үйлчилгээнд амин чухал үүрэг гүйцэтгэж байгаа МХТ-ийн хүртээмжийн талаар огт тусгаагүй байгаа нь илт. Гэтэл дээрх бараа, үйлчилгээний ихэнх нь МХТ-ийн тусламжтайгаар явагдаж байна. Эдгээр хууль, тогтоомжийг хянан хэлэлцэж батлахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл ба тэдний эрх ашгийг хамгаалдаг байгууллага, түүнчлэн бусад хамтрагч талууд, тэдгээрийн дотор эрдэм шинжилгээний болон архитектор, хот төлөвлөгчид, инженерүүд ба дизайнер зэрэг шинжээч, судлаач, мэргэжилтнүүдийн холбоо, нийгэмлэгийн төлөөлөгчидтэй дотно зөвлөлдөж саналыг нь авах нь чухал юм. Хууль тогтоомж нь Конвенцийн (4-р зүйлийн 1 (f) хэсэг)-д заасан шаардлагын дагуу түгээмэл загварыг дагаж мөрдөх зарчим дээр суурилсан байх ёстой. Хууль тогтоомжид хүртээмжтэй байдлын стандартыг заалшгүй дагаж мөрдөх, түүний дотор шаардлагыг биелүүлээгүй этгээдэд хэрэг үүсгэх болон торгох хүртэл шийтгэлийг тусгах нь зүйтэй.

29. Хүртээмжтэй байдлын стандартуудыг хүртээмж зайлшгүй шаардлагатай салбаруудын тухай хуулинд буюу тухайлбал: барилга ба төлөвлөлт дахь биет орчин, иргэний нисэх, автозам, төмөр зам, усан тээврээр зорчих тухай болон мэдээлэл, холбоо ба харилцааны тухай хуулиудад тусгаж өгөх нь ашиг тустай. Хүртээмжтэй байдал нь хөгжлийн бэрхшээл дээр суурилсан ялгаварлан гадуурхалтыг хориглох тухай агуулгын хүрээнд тэгш боломж, тэгш эрх ба тэгш оролцооны тухай ерөнхий ба тусгай хуулиудад илэрлээ олсон байх ёстой. Хөгжлийн бэрхшээлээр нь шалтгаалж нэвтрэхийг хориглох нь ялгаварлан гадуурхах хориотой үйлдэл гэдгийг тодорхой зааж өгөх ёстой. Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биет орчин, тээвэрт нэвтрэх болон мэдээлэл, холбоо ба нийтэд нээлттэй үйлчилгээг хүртэхийг хориглосон тохиолдол гарах юм бол тэдгээр нь өөрийн эрхийг хамгаалах эрх зүйн үр дүнтэй арга хэрэгслээр хангагдсан байх ёстой. Хүртээмжийн стандартыг боловсруулахдаа оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон талт байдлыг харгалзан үзэж тэднийг нас, хүйс болон хөгжлийн бэрхшээлийн төрлөөс нь үл хамааран хүртээмжийг хангах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон талт байдлыг харгалзан үзэх үйл ажиллагааны нэг хэсэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь хүртээмжээ бүрэн эдлэхийн тулд хүмүүс болон амьтны тусламжийг (тухайлбал: туслах хүн дагалдах, дохионы хэлний орчуулагч, тэмтрэн мэдрэх хэлний орчуулагч болон хөтөч нохой ашиглах) авах шаардлагатай байдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Жишээлбэл: хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дагалдаж яваа хөтөч нохойг тухайн барилга байгууламж эсвэл задгай талбайд оруулахыг хориглох нь хөгжлийн бэрхшээл дээр суурилсан ялгаварлан гадуурхалт буюу хориглосон үйлдэл мөн, гэдгийг зааж өгөх ёстой.

30. Хөгжлийн янз бүрийн бэрхшээлтэй иргэдэд зориулж олон нийт болон хувийн хэвшлийн байгууллагуудаас үзүүлж буй төрөл бүрийн үйлчилгээнд хүртээмжийн наад захын стандартыг бий болгох шаардлагатай. Мэдээлэл харилцаа холбооны хүртээмжийн стандартыг боловсруулахдаа Олон улсын харилцаа холбооны нийгэмлэгээс (ОУХХН) гаргасан Харилцаа холбооны үйл ажиллагааны стандартад хүртээмжийн хангалтыг хянах жагсаалт (2006) болон өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан Харилцаа холбооны хүртээмжтэй байдлын тухай (ОУХХН -Т гарын авлага F.790) гарын авлага, удирдамжийг баримтлах нь зүйтэй. Ингэх нь стандартыг боловсруулахдаа түгээмэл загварыг нэгтгэн авч үзэх боломжийг бас нээж өгч байгаа юм. Оролцогч улсууд нь өөрийн орны хувийн хэвшлийн байгууллагуудын урьд өмнө хүртээмжгүй байсан үйлчилгээг аажмаар хүртээмжтэй болгон өөрчлөн сайжруулахад хяналт тавих, үнэлгээ шинжилгээ хийх, хэрэгжүүлэх боломж ба цаг хугацааны үзүүлэлт бүхий эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх хэрэгтэй. Түүнчлэн оролцогч улсууд шинээр нэвтэрч байгаа бүх бараа ба үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийг бүрэн дүүрэн хангасан байхад анхаарч ажиллана. Конвенцийн 4 дүгээр зүйлийн 3 дугаар заалтын дагуу мөрдөх стандартын наад захын хүрээг хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний эрх ашгийг хамгаалдаг байгууллагын төлөөллийг оролцуулан тодруулах шаардлагатай. Конвенцийн 32 дугаар зүйлд заасны дагуу стандартыг бусад оролцогч улс, олон улсын байгууллага, агентлагуудтай хамтран олон улсын хамтын ажиллагааны хүрээнд боловсруулж болно. Оролцогч улсууд нь Мэдээлэл технологийн нийгэмлэгийн дэргэдэх Радио холбооны харилцаа, стандарт хэмжил зүй болон хөгжлийн сектортой хамтран ажиллах нь зүйтэй бөгөөд тус сектор нь МХТ-ийн стандартад хүртээмжтэй байдлыг тусгах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан МХТ-ийн хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагын талаар тус салбарынхаа болон засгийн газрын ажилтнуудын ойлголтыг

сайжруулахад идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлж хүрээгээ улам бүр тэлж байгаа билээ. Хамтын ажиллагааны ийм хэлбэр нь бараа ба үйлчилгээний хоорондын харилцан хамааралд хувь нэмэр оруулах олон улсын стандартыг хөгжүүлэх, өргөжүүлэн тэлэхэд ч боломж олгож байгаа юм. Харилцаа холбооны технологитой холбоотой үйлчилгээний салбарын хүрээнд стандарт тогтоохын тулд оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж үзүүлэх, дохионы хэл болон мэдрэх аргаар орчинтой харьцах дохионы хэл гэх мэт хүртээмжид шинээр нэвтэрч байгаа үйлчилгээнд чанарын наад захын түвшнийг хангаж ажиллах ёстой.

31. Оролцогч улсууд хүртээмжтэй байдлын тухай хууль тогтоомжоо хянаж үзэхдээ хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхах явдлыг устгах хуулийн заалтыг онцгойлон авч үзэх ёстой бөгөөд энэ үндсэн дээр шаардлагатай гэж үзвэл нэмэлт өөрчлөлт ч оруулах боломжтой. Хүртээмж дутагдаж байгаа дараахи хүчин зүйлүүдээс үүдэж хөгжлийн бэрхшээлтэй иргэн олон нийтэд нээлттэй үйлчилгээг авах болон барилга байгууламжид нэвтрэх боломжгүй байгаа бөгөөд тэдгээрийг хамгийн багаар бодоход хөгжлийн бэрхшээл дээр суурилсан ялгаварлан гадуурхалт гэж авч үзнэ. Үүнд:

(а) Хүртээмжийн холбогдох стандартуудыг баталж танилцуулчихаад байхад үйлчилгээ, байгууламжийг хүртээмжгүй гүйцэтгэсэн тохиолдолд;

(б) Зөвхөн (тухайн цаг үеийн нөхцөлд) хэрэгцээ гарсан үед л хүртээмжийн таатай орчин бүрдүүлэх замаар буюу барилга байгууламжид нэвтрэх болон үйлчилгээний хүртээмжид боломж олгох;

32. Оролцогч улсууд хүртээмжтэй байдлын тухай хууль тогтоомжийг хянан хэлэлцэхдээ өргөн хэрэгцээний бараа товарын ханган нийлүүлэлт нь үйл явцын хувьд хүртээмжтэй байдлын шаардлагыг хангасан эсэхийг ажил хэрэг болгон авч үзэх ёстой. Хүртээмжгүй үйлчилгээ ба байгууламжийн үр дагавар буюу тэгш бус байдлыг үүсгэх эсвэл хадгалахад олон нийтийн хөрөнгө мөнгийг ашиглан зарцуулахыг хэрхэвч хүлээн зөвшөөрч болохгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болон тэгш байдлыг нь бодитоор хангахын тулд Конвенцийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу сайн сайхан үйлсийг хэрэгжүүлэх үүднээс өргөн хэрэгцээний бараа товарын худалдан авалтыг зохион байгуулах боломжийг ашиглах ёстой.

33. Оролцогч улсууд хүртээмжтэй байдалд тулгарч байгаа саад бэрхшээлийг олж тодорхойлох үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх цаг хугацааг нарийвчлан тогтоож, учирч байгаа саад бэрхшээлийг арилгахад шаардлагатай хүн хүчний болон материаллаг нөөцөөр хангах ёстой. Нэгэнт ийм мөрийн хөтөлбөр, стратегийг хэлэлцэж баталсан л бол тэдгээрийг зайлшгүй хэрэгжүүлэх ёстой. Хүртээмжтэй байдлыг хангахын тулд оролцогч улсууд хяналтын механизмаа бэхжүүлэх ёстой бөгөөд хүртээмжтэй байдлыг хангахад учирч буй элдэв саад бэрхшээлийг арилгах болон хяналт шалгалтын ажилтнуудыг сургахад шаардагдах зардлыг үргэлжлүүлэн санхүүжүүлэх ёстой. Хүртээмжийн стандартыг ихэвчлэн орон нутагт хэрэгжүүлэх нь

түгээмэл тул стандартын хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий орон нутгийн удирдлагуудыг тасралтгүй сургаж чадавхжуулах нь нэн чухал ач холбогдолтой юм. Оролцогч улсууд нь нэгэнт баталсан төлөвлөгөө, стратеги, стандарт хэмжил зүйн хэрэгжилтийг хангах болон дагаж мөрдүүлэх хяналт шалгалтын зохих чадавхи, эрх мэдэл бүхий хүний нөөцтэй тогтолцоог боловсруулж хяналтын үр ашигтай байгууллагыг үүсгэн байгуулж ажиллуулах үүрэгтэй.

IV. Конвенцын бусад зүйлүүдийн уялдаа холбоо

34. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд биет орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоог ашиглах болон олон нийтэд нээлттэй үйлчилгээг хүртэх боломжийг хангахдаа тэгш эрх ба ялгаварлан гадуурхахгүй байх өнцгөөс хандах нь оролцогч улсуудын хүлээх үүрэг хариуцлага юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд биет орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоог ашиглах болон олон нийтэд нээлттэй үйлчилгээг хүртэх боломжийг нь хориглох нь Конвенцийн 5 дугаар зүйлд заасанчлан: хөгжлийн бэрхшээлийн шинж тэмдгээр ялгаварлан гадуурхсан үйлдэл мөн, хэмээн авч үзнэ. Хүртээмжтэй байдлыг хангах асуудлыг *pro futuro* (эхэлсэн л бол цаашид тууштай үргэлжлүүлэх гэсэн утгатай) агуулгын хүрээнд авч үзье гэвэл бүх нийтэд зориулсан бараа товар, үйлчилгээ, тоног төхөөрөмж болон барилга байгууламжийг цаашид хөгжүүлэхдээ ерөнхий үүргийн чиг хандлагыг тусган хэрэгжүүлэх нь зүйтэй (4-р зүйлийн 1 дүгээр заалт (f)), гэсэн санаа юм.

35. Иргэдийн ухамсар, мэдлэгийг дээшлүүлэх нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах Конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэх урьдчилсан нөхцлийн нэг юм. Хүртээмжтэй байдлыг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тухайн орчныг тохижуулах (энэ нь хэдийгээр чухал боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байх асуудлын зөвхөн нэг тал нь юм) мэтээр явцуу хүрээнд ойлгох нь түгээмэл байгаа бөгөөд оролцогч улсууд нь хамтрагч талуудын дунд хүртээмжийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх талаар байнга, системтэй үйл ажиллагаа өрнүүлэхийг эрмэлзэх ёстой. Хүртээмж нь нийгмийн амьдралын бүх талыг хамардаг тул энэхүү онцлогийг биет орчинд нэвтрэх, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, түүнчлэн үйлчилгээнд хүртээмжтэй байдлыг хангахад онцгойлон анхаарах ёстой. Хүртээмжийн талаарх мэдлэг ухамсарыг дээшлүүлэх нь хүртээмжийн стандартыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын аль аль нь адилхан дагаж мөрдөх шаардлагатайг харуулж байна. Түгээмэл загварын хэлбэр, хийцийн төслийг бүр анхнаас нь хүртээмжтэй байхаар тооцон зохион бүтээх, барьж байгуулах нь өртгийн хувьд бага, мөн эдийн засгийн хувьд хэмнэлттэй байх болно. Хүртээмжийн талаарх ойлголт, ухамсрыг дээшлүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний эрх ашгийг хамгаалдаг байгууллагын төлөөлөл болон техникийн шинжээчидтэй хамтран ажиллах нь чухал. Ялангуяа хүртээмжтэй байдлын стандартыг хэрэгжүүлэх болон дагаж мөрдөхөд хяналт тавих хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд онцгой анхаарах хэрэгтэй. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн хөтөлбөр, үйлчилгээндээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хүртээмжийн байдлыг харгалзан үзэхээс гадна хүртээмжтэй байдлыг дэмжих болон энэ талаарх нийгмийн ухамсар, мэдлэгийг дээшлүүлэхэд идэвхтэй ажиллаж хувь нэмэр оруулах ёстой.

36. Биет орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо болон олон нийтэд нээлттэй үйлчилгээнд хүртээмжтэй байдлыг бүрэн дүүрэн хангах нь Конвенцид заасан олон эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэх амин чухал урьдчилсан нөхцөл юм. Эрсдлийн нөхцөл байдал, байгалийн гамшиг болон зэвсэгт мөргөлдөөнийн үед яаралтай тусламжийн алба нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байх ёстой бөгөөд эс бөгөөс тэдний амь насыг аварч амгалан тайван байдлыг хамгаалах боломжгүй юм. (11-р зүйл).

Гамшгийн дараах сэргээн босголтын үйл ажиллагааны нөхцөлд ч хүртээмжтэй байдал тэргүүлэх чиглэл байх ёстой. Тиймээс гамшгийн эрсдэлийг бууруулах ажил нь хүртээмжтэй, мөн хөгжлийн бэрхшээлийг харгалзан үзсэн байх ёстой.

37. Хууль сахиулах, шүүх бусад эрх мэдлийн байгууллагын байрлаж буй барилга байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн дотогш ороход түвэгтэй, эсвэл тэдгээрээс үзүүлж буй үйлчилгээ, мэдээлэл, харилцаа холбоо нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжгүй байвал шудрага ёсны хүртээмж төдийн чинээ үр дүнгүй л байх болно (13-р зүйл). Түр саатуулах байр, туслах үйлчилгээ болон процедурын журам нь хүртээмжтэй байх ёстой бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг хүчирхийлэл, дарангуйлал, мөлжлөгөөс найдвартай, аюулгүй хамгаалахын тулд хүртээмжтэй байх ёстой (16-р зүйл). Биет орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, үйлчилгээний хүтээмж нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд тухайн орон нутагтаа бие даан чөлөөтэй амьдрах урьдчилсан нөхцөл юм (19-р зүйл).

38. Мэдээлэл, харилцаа холбооны асуудлаар 9 ба 21 дүгээр зүйлүүдийн агуулга нь давхцаж байгаа. 21-р зүйлд, оролцогч улсууд "хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэх, тэр дундаа бусадтай ижил тэгш эрхтэйгээр болон өөрийн сонголтоор харилцаа холбооны бүхий л хэлбэрийг ашиглан мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөөг нь хангахын тулд зохих бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ" гэж заасан байдаг. Ингээд, дараа нь тус зүйлд мэдээлэл ба харилцаа холбооны хүртээмжийг практик амьдралд хэрхэн хангах талаар дэлгэрэнгүй тайлбарласан болно. Энэ нь оролцогч улсуудаас "олон нийтэд зориулсан мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулж хөгжлийн бэрхшээлийн төрлийг нь харгалзан хүртээмжтэй хэлбэр, хэмжээ, технологиор хангах байх"-ыг шаарддаг (21 (а) зүйл). Түүнээс гадна, "хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс албан ёсны харилцаандаа дохионы хэл, Брайл, харилцаа холбооны өсгөх, томруулах төхөөрөмж болон хувилбарт төрөл, хүртээмжтэй бусад бүх арга хэрэгсэл, хэлбэр, загварыг өөрийн сонголтоор ашиглах боломжийг хөнгөвчлөх" (21-р зүйлийн б)) талаар заасан байдаг. Олон нийтэд интернетээр дамжуулан үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн байгууллагуудыг хувьд өөрийн мэдээлэл болон үйлчилгээгээ хөгжлийн бэрхшээлтэй иргэд ашиглаж болохоор хүртээмжтэй хэлбэр, хэмжээтэй (21-р зүйлийн в) байх шаардлагатай. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүний дотор Интернетээр дамжуулан мэдээллийн бизнес хийдэг байгууллагууд ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байхаар үйлчилгээгээ явуулах нь зүйтэй (21-р зүйлийн д)). Мөн 21 дүгээр зүйлд, оролцогч улсууд Конвенцийн 24, 27, 29, 30 дугаар зүйлд заасны дагуу дохионы хэлний хэрэглээг хүлээн зөвшөөрч, дэмжиж ажиллахыг шаарддаг.

39. Сургуульд хүрэх тээврийн хэрэгсэл нь хүртээмжгүй, сургуулийн барилга байгууламж нь хүртээмжгүй, мэдээлэл, харилцаа холбоо нь хүртээмжгүй бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурч боловсрох эрх нь зөрчигдөх болно (Конвенцийн 24-р зүйл). Тиймээс Конвенцийн 9 дүгээр зүйлийн 1 (а) хэсэгт тодорхой заасны дагуу сургууль бүр хүртээмжтэй байх ёстой. Бүх нийтийн боловсролын бүх үйл явц нь, барилга байшингаас гадна мэдээлэл ба харилцаа холбоо, түүний дотор сургуулийн орчин болон ФМ-ийн систем, бусад туслах үйлчилгээнүүд болон тусгайлан тохижуулсан орчныг оролцуулан хүртээмжийн байдлыг зайлшгүй хангасан байх ёстой. Хүртээмжтэй байдлыг боловсролын салбарт дэмжихийн тулд сургалтын хөтөлбөрийн агуулгыг дохионы хэл, Брайл, бусад хувилбарт бичгийн цагаан толгой дээр явуулж хөгжүүлэх шаардлагатай бөгөөд хараа ба сонсголын бэрхшээлтэй эсвэл хараа ба сонсголын бэрхшээлийн аль аль нь давхацсан суралцагсдын харилцаа ба чиг баримжаандаа (24 дүгээр зүйл, 3 дахь заалт (а)) ашигладаг хэл, арга хэлбэр ба тоног төхөөрөмжид нь тохирсон хүч нэмэгдүүлэх нэмэлт хэрэгсэл болон сургалтын хувилбарт арга ба хэрэгсэл, загварт онцгойлон анхаарах хэрэгтэй. Сургалтын арга хэрэгсэл нь хүртээмжтэй байхаас гадна хүртээмжтэй орчинд явагдах ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагсдын орчин нь бүхэлдээ боловсролын бүхий л үйл явцын турш тэдний оролцоо ба тэгш байдлыг баталгаатай хангахуйц байдлаар бүрдсэн байх ёстой. Конвенцийн 24 дүгээр зүйлийг бүрэн хэрэгжүүлэх асуудлыг хүний эрхийн бусад үндсэн баримт бичгүүд, түүнчлэн НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Боловсрол дахь ялгаварлан гадуурхалтын эсрэг Конвенцийн заалтуудтай уялдуулан авч үзэх ёстой.

40. Хэрэв эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын угтах өрөө нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ороход хүртээмжгүй бол тэдгээр үйлчилгээг авах ямарч боломжгүй болно. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа байр нь өөрөө хүртээмжтэй байлаа ч хүртээмжтэй тээврийн хэрэгсэл байхгүй бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчилгээ үзүүлж буй газрууд руугаа хүрч очих боломжгүй. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой бүхий л мэдээлэл, харилцаа холбоо нь дохионы хэл, Брайл, хүртээмж бүхий цахим хэлбэртэй, бас өөр бусад бичгийн хувилбартай, мөн харилцаа холбооны хүч нэмэгдүүлэх нэмэлт хэрэгсэл болон хувилбарт хэлбэр, хэрэгсэл, загвартай байх ёстой. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ жендерийн асуудлыг анхаарч үзэх нь ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд ба охидод зориулсан нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ, тэр дундаа эмэгтэйчүүдийн үзлэг болон эх барих үйлчилгээнд чухал ач холбогдолтой юм. Хэрэв ажлын байр нь хүртээмжгүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс Конвенцийн 27-р зүйлд заасанчлан, ажиллаж хөдөлмөрлөх эрхээ бүрэн дүүрэн эдэлж чадахгүй. Ийм учраас 9 дүгээр зүйлийн 1 (а) хэсэгт тодорхой заасанчлан, ажлын байр нь хүртээмжтэй байх ёстой. Ажлын байрыг хүртээмжтэй болгон бэлдэхээс татгалзахыг хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхах үйлдэл хэмээн авч үзнэ. Ажлын байрны хүртээмжтэй орчноос гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажлын байрандаа хүрэхийн тулд тээврийн хүртээмжтэй хэрэгсэл, мөн бусад туслах үйлчилгээ шаардлагатай байдаг.

41. Ажил төрөлд хамааралтай бүхий л мэдээлэл буюу ажлын байрны зар сурталчилгаа, сонгон шалгаруулах үйл явц, ажлын байран дахь ярилцлага, харилцаа нь хүртээмжтэй байх ёстой бөгөөд эдгээр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх үйл явцын нэгэн хэсэг болохын хувьд дохионы хэл, Брайл, цахимын хүртээмжтэй хэлбэр, бичгийн бусад хувилбарт хэлбэр, хүч нэмэгдүүлэх нэмэлт хэрэгсэл төхөөрөмж болон харилцаанд хүртээмжтэй горим , хэлбэр, загвартай байх ёстой. Үйлдвэрчний болон хөдөлмөрлөх эрхийг хамгаалдаг бүх байгууллагууд нь хандахад хүртээмжтэй байх ёстой бөгөөд, үүний нэгэн адил суралцах болон мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх сургалт зэрэг нь ч хүртээмжтэй байх ёстой. Жишээлбэл, ажилчид болон суралцагсдад зориулсан гадаад хэл ба компьютерийн курс нь хүртээмжтэй орчинд, хүртээмжтэй хэлбэр, горим, арга хэрэгсэл, хэлбэр, хэмжээтэй явагдах ёстой.

42. Конвенцийн 28 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргаа ба нийгмийн хамгаалал нь ижилхэн нэг түвшний стандарттай байх талаар тусгасан. Оролцогч улсууд нь нийгмийн хамгааллын үндсэн арга хэмжээнийхээ зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээ ба үйлчилгээг хүртээмжтэй байдлаар, хүртээмжтэй барилга байгууламжид, түүнчлэн тэдгээрт хамаарах бүхий л мэдээлэл ба харилцаа холбоо нь дохионы хэл, Брайл, цахимын хүрэлцээтэй хэлбэр, бичиг үсгийн бусад хувилбаруудыг ашиглах болон хүч нэмэгдүүлэх нэмэлт төхөөрөмж ба хувилбарт арга хэрэгслийг хүртээмжтэй байхаар зохион байгуулна. Нийгмийн орон сууцны хөтөлбөрүүд нь бас хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настанд зориулсан хүртээмжтэй орон сууцыг санал болгох ёстой.

43. Конвенцийн 29 дүгээр зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэд улс төр ба олон нийтийн амьдралд оролцох эрх, төрийн үйл хэргийг барилцах эрхийг баталгаажуулсан байдаг. Оролцогч улсууд нь санал хураах журам, тоног төхөөрөмж болон материалыг тохиромжтой, хүртээмжтэй, ашиглахад ойлгомжтой ба хялбар байхаар баталгаажуулаагүй тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэд дээрх эрхүүдээ адил тэгш, үр дүнтэй эдлэх боломжгүй болно. Түүнчлэн сонгуульд оролцож буй улс төрийн намууд болон нэр дэвшигчдээс зохион байгуулж буй хурал, цуглаан болон тараах материалууд нь хүртээмжтэй байх ёстой бөгөөд эсрэг тохилдолд улс төрийн үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бусадтай ижил тэгш оролцох эрх нь зөрчигдөх болно. Төрийн албанд нэгэнт сонгогдсон хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь бусад сонгогдсон иргэдийн адил бүрэн эрхээ эдлэх боломж нөхцлөөр хангагдсан байх ёстой.

44. Хүн бүр урлаг, спортоор хичээллэх, зочид буудалд байрлах, мөн ресторан ба баараар үйлчлүүлэх эрхтэй. Гэвч концертын танхим хүртэл зөвхөн шат байвал тэргэнцэртэй хүмүүс тоглолт үзэх боломжгүй. Харааны бэрхшээлтэй иргэд уран зургийн галерейд сонсох төхөөрөмж бүхий тайлбаргүй бол тухайн уран зургийн гайхамшгийг мэдэрч чадахгүй. Субтитр буюу хадмал бичгийн орчуулгагүй бол сонсголын бэрхшээлтэй иргэд тухайн киног бүрэн ойлгохгүй. Сонсголын бэрхшээлтэй иргэд дохионы хэлний орчуулгагүй бол театрын жүжгийг үзээд ойлгохгүй. Оюун ухааны бэрхшээлтэй иргэд ном уншихад хялбар зориулалт бүхий нэмэлт төхөөрөмж эсвэл өөр хувилбарт хэрэгслийн сонголт байхгүй бол ном унших боломжгүй болно. Конвенцийн 30 дугаар зүйлд,

хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусадтай адил соёлын амьдралд ижил тэгш оролцох эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрөхийг оролцогч улсуудаас шаарддаг. Оролцогч улсууд дараах чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

(а) Соёлын холбогдолтой материал нь ашиглахад хялбар буюу хүртээмжтэй хэлбэртэй байх;

(б) Телевизийн хөтөлбөр, кино, театр болон соёлын бусад бүх арга хэмжээг хүртээмжтэй хэлбэрт шилжүүлэх;

(в) Театр, музей, кино театр, номын сан, аялал жуулчлалын үйлчилгээ гэх мэт соёлын арга хэмжээнүүд эсвэл үйлчилгээний газрууд, түүнчлэн үндэсний түүх, соёлын ач холбогдол бүхий хөшөө дурсгал болон газруудад ч гэсэн хүртээмжтэй байдлыг бүрдүүлэх ёстой. Зарим тохиолдолд үндэсний өвийн нэгэн хэсэг болох түүх, соёлын дурсгалт газруудад нэвтрэх боломж нь хэцүү төвөгтэй байж болох юм. Гэсэн хэдий ч оролцогч улсууд эдгээр газруудад хүртээмжийг бий болгохыг хичээх үүрэгтэй. Эдүгээ түүх, соёлын өвөрмөц бөгөөд онцлог байдлыг нь алдагдуулахгүйгээр хүртээмжтэй байдлыг бүрдүүлж чадсан үндэсний түүх, соёлын ач холбогдол бүхий олон газрууд байна.

45. “Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өөрсдийн бүтээлч, урлагийн болон оюуны чадавхиа хөгжүүлэх болон ашиглах боломжийг олгоход зориулсан зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” (30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг). “Оролцогч улсууд олон улсын эрх зүйн хүрээнд оюуны өмчийн эрхийг хамгаалсан хууль тогтоомжууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд соёлын материалтай танилцахад ньүндэслэлгүй эсвэл ялгаварлан гадуурхсан байдалтай элдэв саад тотгор учруулахгүй байх талаар зохих бүх арга хэмжээг авна” (30 дугаар зүйлийн 3 дахь хэсэг) гэж заасан. Хэвлэгдсэн бүтээлийг хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэдэд хялбаршуулан хүртээмжтэй болгох тухай 2013 оны 6-р сард батлагдсан Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын Марракешийн Гэрээ буюу Otherwise Print Disabled нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тухайлбал, хилийн чинадад эсвэл өөр улсад амьдарч буй үндэсний цөөнхийн гишүүн болон харилцаандаа ижил хэл, хэрэгсэл ашигладаг, түүний дотор өдөр тутмын хэвлэлийн материалыг уншихад саад бэрхшээлтэй тулгардаг иргэдэд соёлын материалтай танилцахад хүртээмжтэй байх үндэслэлийг хангаж өгдөг бөгөөд үндэслэлгүй эсвэл ялгаварлан гадуурхах саад бэрхшээлийг үгүйсгэсэн байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай Конвенцид: хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь бусадтай адил өөрийн соёл болон хэлний өвөрмөц онцлогийг хүлээн зөвшөөрч дэмжих эрхтэй, гэж заасан байдаг. 30 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: дохионы хэл болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн соёлыг хүлээн зөвшөөрч дэмжихийг онцолсон байдаг.

46. Конвенцын 30 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт: хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, спортын арга хэмжээнд бусадтай адил тэгш эрхтэй оролцох боломжийг олгохын тулд оролцогч улсууд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ, гэж заасан. Үүнд:

(а) хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортын бүх түвшний үндсэн үйл ажиллагаанд аль болох өргөнөөр оролцуулахыг хөхүүлэн дэмжих;

(б) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өөрсөддөө зориулсан спорт, амралт зугаалгын үйл ажиллагааг зохион байгуулах, хөгжүүлэх, оролцох боломжоор хангах, үүний тулд бусадтай ижил тэгш эрхийн үндсэн дээр зохих заавар зөвлөмж өгөх, сургалт явуулах, нөөцөөр хангах явдлыг дэмжих;

(в) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спорт, амралт зугаалга, аялал жуулчлалын газруудад нэвтрэх боломжоор хангах;

(г) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг бусад хүүхдүүдтэй нэгэн адил тоглох, амралт, чөлөөт цагаа өнгөрөөх, спортын үйл ажиллагаа, тэр дундаа эдгээр нь сургуулийн тогтолцооны үйл ажиллагааны нэгэн хэсэг байсан ч оролцох боломжоор хангах;

(е) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг амралт, аялал жуулчлал, чөлөөт цаг, спортын үйл ажиллагааг зохион байгуулагч нарын төрөл бүрийн үйлчилгээг авах боломжоор хангах.

47. Конвенцын 32 дугаар зүйлд, олон улсын хамтын ажиллагаа нь хүртээмжтэй байдал, бүх нийтийн загварыг дэмжих гол хэрэгсэл болох ёстой, гэж заасан. Хороо нь олон улсын хөгжлийн агентлагууд МХТ-ийг хөгжүүлэхэд чиглэсэн туслах төслүүдийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч хүртээмжийн бусад дэд бүтцийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхийг санал болгосон байна. Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд шинээр хийгдсэн бүх хөрөнгө оруулалтыг эдүгээ учирч байгаа саад бэрхшээлийг арилгах болон дахин шинээр үүсэхээс урьдчилан сэргийлэхэд ашиглах ёстой. Төсвийн хөрөнгийг тэгш бус байдал шинээр түгэн дэлгэрэхэд ашиглаж болохгүй. Бүх шинэ объект, дэд бүтэц, байгууламж, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүст бүрэн хүртээмжтэй байх ёстой. Олон улсын хамтын ажиллагааг зөвхөн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртээмжтэй болгоход хөрөнгө оруулалт хийх замаар бус дэлхий даяар амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй олон сая хүмүүсийн амьдралыг сайжруулах, хүртээмжтэй болгоход бодит өөрчлөлтүүдийг гаргаж байгаа сайн жишээ, туршлагын талаарх мэдээлэл болон ноу-хауг солилцоход ашиглах ёстой. Стандартчиллын чиглэлээр олон улсын хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой бөгөөд үүний нэг хэлбэр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг хүртээмжтэй байдлын стандартыг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах чиглэлээр зохиогдож буй үндэсний болон олон улсын үйл ажиллагаанд оролцуулах замаар дэмжих явдал юм.

Хүртээмжтэй байдал нь тогтвортой хөгжлийн аливаа хүчин чармайлтын салшгүй хэсэг байх ёстой бөгөөд ялангуяа 2015 оны хөгжлийн хөтөлбөрийн агуулгын хүрээнд ач холбогдол нь улам бүр өссөөр байна.

48. Хүртээмжтэй байдлын хяналт нь Конвенцийн хэрэгжилтэд тавих үндэсний болон олон улсын мониторингийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

Конвенцын 33 дугаар зүйлд, оролцогч улс орнууд нь конвенцийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар засгийн газрынхаа хүрээнд тусгай зохицуулагч нарыг томилох шаардлагатай бөгөөд хэрэгжилтэд хяналт тавих нэг эсвэл хэд хэдэн бие даасан механизмыг багтаасан үндэсний тогтолцоог бий болгон ажиллуулах шаардлагатайг заасан. Хяналтын үйл явцад иргэний нийгмийн төлөөлөл ч хамрагдаж бүрэн оролцох нь нээлттэй. 9 дүгээр зүйлийг зохих ёсоор хэрэгжүүлэх арга хэмжээг авч үзэхдээ 33 дугаар зүйлийн хүрээнд байгуулагдсан байгууллагуудтай зохих ёсоор зөвлөлдөх нь нэн чухал юм. Эдгээр байгууллагууд нь, тухайлбал, хүртээмжийн байдлын талаар үндэсний стандартыг боловсруулахад оролцох, одоо мөрдөгдөж буй хууль тогтоомж болон хуулийн төсөлд санал өгөх, хууль тогтоомжийн төсөл болон улс төрийн тогтоол шийдвэрүүдэд санал оруулах, түүнчлэн хүн амын ухамсар мэдлэгийг дээшлүүлэх болон боловсролын кампанит ажилд бүрэн дүүрэн оролцох боломжоор хангагдах ёстой. Конвенцийн хэрэгжилтэд үндэсний болон олон улсын хяналт тавих үйл явц нь хүртээмжтэй хэлбэрээр буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдгээрийн төлөөллийн байгууллагуудын оролцоог бүрэн дүүрэн дэмжсэн байдлаар явагдах ёстой.

Конвенцын 49 дүгээр зүйлд, Конвенцийн баримт бичиг нь хүртээмжийн хэлбэр, хэмжээний хувьд хүрэлцээтэй байхыг заасан байдаг. Энэ нь олон улсын хүний эрхийн гэрээнд орсон шинэлэг зүйл бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц нь цаашид батлагдах бүх гэрээ хэлэлцээрийн хувьд жишиг баримт бичиг болох юм.

¹ Ерөнхий Ассамблейн чуулганы тогтоолын хавсралт 48/96.

² 2003 онд Женевт хотноо мэдээллийн нийгмийн асуудлаарх дэлхийн дээд хэмжээний уулзалтын эхний шатанд батлагдсан “Зарчмын тунхаглал” буюу Мэдээллийн нийгмийг бий болгох ба шинэ мянганы дэлхийн сорилт”-ыг үзнэ үү (WSIS-03/ЖЕНЕВА/DOC/4 -E), догол мөр. 25.